# Гадаад ажилчин зэрэг гадуурхах нийгмийн давхарга эмчилгээний үйлчилгээ дэмжих үйл ажиллагааны танилцуулга

1. **Үйл ажиллагааны зорилго**

– Эмчилгээний батлан даах тогтолцоо байсан ч эмчилгээний ашиг тусыг авч чадахгүй байгаа дотоодод оршин сууж байгаа гадаад ажилчин зэрэгт эмчилгээний үйлчилгээг хангаж хүний эдлэх ёстой хамгийн бага эрүүл амьдралын чанарыг сахин хамгаалах гэж байна.

2. **Дэмжлэгт хамрагдах хүн**

– Эрүүл мэндийн даатгалгүй бөгөөд дотоодод оршин суух хугацаа 90 хоногоос дээш гадаадын өвчтөн дунд дараах нөхцөлд хамаарах хүн

<table>
<tr><th>Ангилал</th><th>Дэмжлэгт хамрагдах хүний эрх</th><th colspan="2">Бүрдүүлэх бичиг баримт</th><th>Холбогдох виз</th></tr>
<tr><td rowspan="2">Гадаад ажилчин ба түүний хүүхэд</td><td>Дотоодод байршиж байгаа үйл ажиллагааны газарт хөдөлмөр эрхэлсэн буюу одоо хөдөлмөр эрхэлж байгаа хүн</td><td>• Гадаад паспорт<br>• Гадаадын иргэн бүртгэлийн үнэмлэх<br>• Түрээсийн гэрээ<br>• Батлан даагчийн бичиг</td><td>1–с дээш</td><td rowspan="2">• D–3, D–4, E–6, E–9, E–10<br>• B–1, B–2, C–2, C–3, H–2 : Хөдөлмөр эрхлэлт үнэн болохыг батлах</td></tr>
<tr><td>Дээрх гадаад ажилчны 18–с доош насны хүүхэд</td><td colspan="2">• <Нэмж батлах><br>Эцэг эхийн мэдүүлэг бичиг (Гэр бүлийн тодорхойлолт)</td></tr>
<tr><td rowspan="2">Иргэний харьялалд багтахын өмнө гэрлэсэн эмэгтэй цагаач ба түүний хүүхэд</td><td>Солонгос хүнтэй гэрлэсэн(хамт амьдарсныг эс тооцох) байдлаар, одоо солонгосын харьялалд багтаж чадаагүй гадаад харьяалалын эмэгтэйчүүдээс гэрээсээ зугтах, нуугдан зайлах зэргийн байдалд байгаа хүн</td><td colspan="2">• Гадаад паспорт<br>• Өрхийн бүртгэлийн хуулбар<br>• Гэрээсээ зугтах, нуугдан зайлах байдлын одорхойлолт</td><td rowspan="2"></td></tr>
<tr><td>Дээрх гэрлэсэн эмэгтэй цагаачийн 18–с доош насны хүүхэд</td><td colspan="2">• <Нэмж батлах><br>Эцэг эхийн мэдүүлэг бичиг (гэр бүлийн тодорхойлолт)</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| **Гамшигт нэрвэгдэгсэд зэрэг ба түүний хүүхэд** | Гамшигт нэрвэгдэгсдийн хүлээн зөвшөөрлийг авсан буюу гамшигт нэрвэгдэгсэд хүлээн зөвшөөрлийг өргөдөл гаргасан хүн(шүүхдэж байгаа хүн хамрагдана), хүмүүнлэг ёсны учир шалтгаанаар оршин суух зөвшөөрөл авсан хүн | • Гадаад иргэн бүртгэлийн үнэмлэх | • F-2-2, F-2-4, G-1-F, G-1-6 G-1-E, G-1-5 |
| | Дээрх гамшигт нэрвэгдэгсдийн 18-с доош насны хүүхэд | • <Нэмж батлах> Эцэг эхийн мэдүүлэг бичиг (гэр бүлийн тодорхойлолт) | |

## 3. Дэмжлэгийн агуулга

– Дараах зүйлийн үзлэг эмчилгээний зардал(эмчилгээний үйлчилгээнд хамрагдахгүй болон сонгон үзлэг эмчилгээний зардал хамаарахгүй) хамгийн их нь 5 сая вон байх

① Эмнэлэгт хэвтэх ба тухайн өдөр амбулаторийн мэс засал(18-с дээш насны өвчтөний энгийн амбулаторийн үзлэг эмчилгээ, шинжилгээ нь дэмжлэгээс хамаарахгүй)

② Төрөхийн өмнөх эмчийн үзлэг(* Эрүүл мэнд ба нийгмийн хангамжийн яамнаас зарласан эмчилгээ сувилалын эмчилгээний үйлчилгээнд хамрагдах хүний шинжилгээ)

③ Жижиг үйлдвэрт гарсан үйлдвэрлэлийн осол

④ 18 наснаас доош гадаад ажилчны хүүхэд, иргэний харьяалалд багтахын өмнө гэрлэсэн эмэгтэй цагаачийн хүүхэд, гамшигт нэрвэгдэгсдийн хүүхдийн амбулаторийн эмчилгээ

## 4. Дэмжлэгийн үйл явц

① Үйл ажиллагаа хэрэгжүүлэх эмчилгээний байгууллагад зочлох

② Хариуцагчтай ярилцах(дэмжлэгт хамрагдаж болох үгүйг батлах болон дэмжлэгт хамрагдах хүнийг сонгон шийдвэрлэх)

③ Эмнэлэгт хэвтэх зэрэг үзлэг эмчилгээ(дэмжлэгт хамрагдах хүн дунд хүүхдийн амбулаторийн үзлэг эмчилгээ хамрагдана)

④ Эмчилгээ үйлчилгээний тусламж дуусах(эмнэлгээс гарах)

⑤ Үйл ажиллагаа хэрэгжүүлэх эмчилгээний байгууллагын нэхэмжилсэн үзлэг эмчилгээний зардал тооцоо хийх(Бүсань хот)

5. **Хэрэгжүүлэх эмчилгээний байгууллага**

① Бүсань өргөн уудам хотын эмчилгээний клиник : Клиникийн албан ажлын баг (☎ 051-888-2812)

② Бүсань их сургуулийн эмнэлэг : Нийгмийн ажлын танхим(☎ 051-240-7494)

③ Хүн ам эрүүл мэнд ба нийгмийн хамгааллын нийгэмлэг Бүсань салбар Гэр бүлийн эрүүл мэндийн клиник : Дэмжлэгийн баг(☎ 051-638-6906)

④ Өнсөн эмчилгээний сан Жо Өнь Сам Сөнь эмнэлэг : Нийгмийн ажлын танхим (☎ 051-310-9207)

※ Бүсань өргөн уудам хот : Эрүүл мэнд ариун цэврийн тасаг (☎ 051-888-2812)

6. **Хэлмэрчлэх үйлчилгээний дэмжлэг**

- Эмчилгээний байгууллагын хариуцагчид урьдчилан хүсэлт гаргавал үнэгүй хэлмэрчлэх үйлчилгээ үзүүлэх

※ **Дээрх үйл ажиллагаа нь эрүүл мэнд ба нийгмийн халамжийн яам, Бүсань өргөн уудам хотын дэмжлэгийн хөрөнгө санхүүжилтээр зохион байгуулагддаг.**